



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 208


Улаанбаатар хот

“Шинэхэн инвест” ХХК-д банк бус
санхүүгийн үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Шинэхэн инвест” ХХК-д банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Шинэхэн инвест ББСБ” ХХК /Б.Хаш-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолыг хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Нацагдорж/-нд даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ,
ДЭД ДАРГА



Э.БАТБОЛД